



**MNR**  
MONGOLIAN NATIONAL  
REPORTING AUDIT

АУДИТ  
БАТАЛГААЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭ

## **АУДИТОРЫН ТАЙЛАН**

**ГАН ХИЙЦ ХК-ИЙН  
2022 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР  
ТАСАЛБАР БОЛГОСОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫНТАЙЛАН	6-7
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙНТАЙЛАН	8
МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9-10
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	11-28

**ГАН ХИЙЦ ХК  
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

---

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.Оюунзул

АЛБАН ХАЯГ

УБ, СХД, 7-р хороо, Баянхонгуу, Өөрийн байр

ХАРИЛЦАГЧ БАНК

Худалдаа Хөгжлийн Банк ХК, Хаан банк ХК

АУДИТОР

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХК



ГАН ХИЙЦ

ХУВЬЦААТ КОМПАНИ

БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ.

ХУДАЛДАА, БАРИЛГА УГСРАЛТ

Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг.

7-р хороо, Баянхаануу зөвийн байр

Утас: 70172467, Факс 70182448

Web site: [www.gankhiits.mn](http://www.gankhiits.mn)

E-mail: [info@gankhiits.mn](mailto:info@gankhiits.mn)

Г  
“МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ  
ТАЙЛАГНАЛ АУДИТ”-д

2023/03/07 № 01/35  
Ганай - НЫ

Г  
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН  
МЭДЭГДЭЛ

Захирал Даваасүрэн овогтой Оюунзул би “Ган хийц” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын хувьд, ерөнхий нягтлан бодогч Сүхбаатар овогтой Энхзаяа би гүйцэтгэх удирдлагын хувьд ард хавсаргасан 1-ээс .... хуудас дахь “Ган хийц” ХК-ийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тодруулгуудыг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.



Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАГНАЛ**  
**АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза  
оффис 6 давхар, 607 тоот  
Утас: 99117121; 89601000  
И-мэйл: info@mnraudit.mn

2023/03/07 дугаар 23-01/174

Танай \_\_\_\_\_ - ны дугаар \_\_\_\_\_ -т

**Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАЛ****Дүгнэлт**

Бид “ГАН ХИЙЦ” ХК (‘Компани’ гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн тайллан тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланда аудит хийж гүйцэтгээлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бухий л материаллаг асуудлаар Компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нийтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нийтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн билүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний гаргасан тайланда томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материалын алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнз.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн ўйл ажиллагааг зогсоо юм уу татаан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхэс өөр аргагүй байхаас бусад тохиолдоод санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу ўйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчмитай холбоотой

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлэх үүрэг хариуцлага (Ургэлжлэл)

асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээн. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

#### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлэх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгэлжтэй аудиторын тайлан гаргах нь билдний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийн байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нелөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлээмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримтладаг. Түүчинэн билд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрэдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрэдэлд тохиорохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиromжийт аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрэдээн нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрэдэлээс харьцангуй их байдал, учир нь залиландаа хүйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшиох явдуулд багтсан байж болно.
- Нягтландаа бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохицой хэрэглэсэн эсэх, мен олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжийд мэдэгдэхүүц өргөлзөө үүсгэхүүц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулак эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах эдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондoo үндэслэн билд дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод ханалтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилицдаг

#### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан Монгол Улсын “Компанийн тухай хууль” -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “ГАН ХИЙЦ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агууллын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХК  
Улаанбаатар хот, Монгол Улс  
2023 оны 03 дугаар сарын 07



Ч.Баттөмөр  
Мэргэшсэн нягтлан бодогч, Партиер

**ГАН ХИЙЦ ХК**

**АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>Тодруулга</i>	<i>2021 он</i>	<i>2022 он</i>
Борлуулалтын орлого /цэвэр/	<b>16</b>	3,461,006	7,340,486
Борлуулалтын өртөг	<b>17</b>	(2,587,673)	(6,140,742)
<b>Нийт ашиг</b>		<b>873,333</b>	<b>1,199,744</b>
Түрээсийн орлого	<b>18</b>	-	271,291
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого		-	127,307
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий удирдлагын зардал	<b>19</b>	(716,499)	(760,178)
Санхүүгийн зардал		(7,151)	(105,681)
Бусад зардал		(93,121)	(24,028)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	<b>20</b>	(50)	8,149
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө даснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)		(60,499)	(20,273)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>(3,987)</b>	<b>696,331</b>
Орлогын татварын зардал	<b>13.1</b>	14,968	72,126
<b>Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг</b>		<b>(18,956)</b>	<b>624,204</b>

ГАН ХИЙЦ ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Мянган төгрөгөөр ХӨРӨНГӨ	Тодруулга	2021 он		2022 он	
<b>Эргэлтийн хөрөнгө</b>					
Монгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	70,668		335,979	
Дансны авлага	5	3,291,984		2,096,124	
Татвар, НДШ-ийн авлага	6	-		37,805	
Бусад авлага	7	263,107		9,628	
Бусад санхүүгийн хөрөнгө	8	-		5,144	
Бараа материал	8	1,337,341		4,332,245	
Урьдчилж төлсөн төлбөр	9	1,206,431		234,754	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>6,169,531</b>		<b>7,051,679</b>	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>					
Үндсэн хөрөнгө	10	1,745,551		1,923,160	
Биет бус хөрөнгө	11	-		2,242	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		323,133		323,133	
Хойшлогдсон татварын хөрөнгө		-		-	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>2,068,684</b>		<b>2,248,535</b>	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>8,238,215</b>		<b>9,300,214</b>	
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>					
Дансны өглөг	12	4,361,920		2,437,814	
Цалингийн өглөг		5,049		391	
Татварын өглөг	13	465,259		252,238	
НДШ-н өглөг		48,100		11,955	
Банкны богино хугацаат зээл		500,000		1,375,000	
Хүүний өглөг		-		-	
Ногдол ашгийн өглөг		-		96,094	
Урьдчилж орсон орлого		2,599,452		4,244,391	
Нөөц /өр төлбөр/		-		-	
Бусад богино хугацаат өр төлбөр	14	-		-	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>7,979,780</b>		<b>8,417,883</b>	
Урт хугацаат зээл		-		-	
Нөөц /өр төлбөр/		-		-	
Хойшлогдсон татварын өр		-		-	
Бусад урт хугацаат өр төлбөр		-		-	
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>		<b>-</b>	
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>7,979,780</b>		<b>8,417,883</b>	

**Өөрийн хөрөнгө**

	15		
Хувийн		24,246	24,246
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		798,701	798,701
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг		(564,512)	59,384
Эздийн өмчийн дүн		<b>258,435</b>	<b>882,331</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>8,238,215</b>	<b>9,300,214</b>



MNR-AUDIT

ГАН ХИЙЦ ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

<i>Мянган тогrogөөр</i>	<i>Өмч</i>	<i>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</i>	<i>Хуримтлагдсан ашиг</i>	<i>Нийт дүн</i>
<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>24,246</b>	<b>798,701</b>	<b>(545,555)</b>	<b>277,392</b>
Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(18,956)	<b>(18,956)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
<b>2021 оны 12-р сарын 31</b>	<b>24,246</b>	<b>798,701</b>	<b>(564,511)</b>	<b>258,436</b>
Бүртгэлийн бодлогын алдаа	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	<b>24,246</b>	<b>798,701</b>	<b>(564,511)</b>	<b>258,436</b>
Тайлант үсийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	624,204	<b>624,204</b>
Зарласан ногдол ашиг	-	-	309	<b>309</b>
<b>2022 оны 12-р сарын 31</b>	<b>24,246</b>	<b>798,701</b>	<b>59,384</b>	<b>882,331</b>

ГАН ХИЙЦ ХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

<i>Мянган төгрөгөөр</i>	<i>2021 он</i>	<i>2022 он</i>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,673,915</b>	<b>10,428,868</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,673,915	10,428,725
Даатгалын нехвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Бусад мөнгөн орлого	-	143
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,341,905</b>	<b>10,559,419</b>
Ажилчдад төлсөн	406,773	385,944
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,953	173,052
Бараа материал худалдан авахад төлсөн	3,724,312	9,328,366
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	4,434	21,788
Түлш, шатахуун, тээврийн хөлсөнд төлсөн	4,567	2,318
Хүүний төлбөр төлсөн	7,151	101,982
Татварын байгууллагад төлсөн	39,224	460,299
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	52,491	85,670
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,667,990)</b>	<b>(130,551)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>-</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад олгосон зээл болон мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>484,535</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	484,535
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>(484,535)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>500,000</b>	<b>1,000,000</b>
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000	1,000,000
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>125,000</b>
Зээл авсан, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	125,000
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-

Төлсөн ногдол ашиг

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	500,000	875,000
Валютын ханшийн зөрүү	(50)	5,397
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,168,040)	265,311
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,238,708	70,668
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,668	335,979

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь барилгын төмөр хийц үйлдвэрлэл, зочид буудал, цайны газар болно.

**ГАН ХИЙЦ ХК** нь 100 хувийн дотоодын хөрөнгө оруулалттай 2006 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж 9010001016 тоот дугаар бүхий, 2090988 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Даваасүрэн овогтой Оюунзул нь түйцтэж захирал бөгөөд уг компани нь нээлттэй хувьцаат компани юм.

Компанийн албан ёсны хаяг: УБ, СХД, 7-р хороо, Баянхшуу,Өөрийн байр

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

##### 2.1 Тайллан бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд Олон улсын нягтлан бодох бүртгэл болон стандартын зөвлөөс гаргасан Санхүү тайлагналын олон улсын стандартуулын ("СТОУС") дагуу бэлтгэгдсэн болно.

Компанийн санхүүгийн тайлангуудыг түүхэн өргтийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан болно.

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товchoo

###### a. Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайландаа эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнө, түүнтэй адилтгах хөрөнгө  
Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.

Өр төлбөр нь дараах тохиоллцуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД- 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### б. Гадаад валютын хөрвүүлэлт

Компанийн санхүүгийн тайланг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээг хүлээн зөвшөөрөх шаардлага хангасан өдрийн ханшаар мөнгөн нэгжруү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютын бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Бүх зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Түүхэн өргтөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг тэдгээрийн анхны гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютын хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр хэмжигдэх, мөнгөн зүйслийн хөрвүүлээс үссэн олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адиллаар хүлээн зөвшөөрнө(өөрөөр хэлбэл бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланда хүлээн зөвшөөрөгдсэн зүйлийн ханшийн зөрүүнэс үссэн олз, гарзыг мөн адил бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланда бүртгэнэ).

###### в. Борлуулалтын орлого

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээс хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татвар зөвзэл хураамжийг хассан дунгэр хүлээн зөвшөөрнө.

Орлогыг хүлээн зөвшөөрөгдхөөс өмнө дараах тусгай хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангах ёстой.

###### Үйлчилгээний орлого

Үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний эцсийн үр дүнг найдвартай тооцож болохоор байвал балансын өдрөөр уг ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатанд хамаарах орлогыг хүлээн зөвшөөрнө. Дараах нөхцөл бүрдсэн үед аливаа ажил гүйлгээний үр дүнг үнэн зөв тооцож болно.

Үүнд:

- Орлогын үр дүнг найдвартай тооцож болохоор байх
- Тухайн ажил гүйлгээнд хамаарах эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай
- Тайлангийн өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг бодитойгоор тооцож болохоор байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан зардал болон уг ажил гүйлгээг гүйцэх өртгийг найдвартай тодорхойлж болохоор байх

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД- 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### в. Борлуулалтын орлого(үргэлжлэл)

###### Хүүний орлого

Хүүний орлогыг үр ашигт хүүний аргад үндэслэн хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүүний арга гэдэг нь хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн бүх хэрэглүүр, хүүний орлогыг шаардлагатай үед санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн бүртгэлийн дүнтэй цэвэршүүлсэн болино хугацааны буюу санхүүгийн хэрэглүүрийн таамагласан хугацаанд тооцоолсон, ирээдүйд хүлээж авах буюу төлөх менгэн урсталин бууруулсан хүүний түвшинг ашиглах юм. Хүүний орлогыг орлого зардлын тайлангийн “Бусад орлого”-д бүртгэнэ.

###### г. Зардал

Зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад эдийн засгийн өгөөжийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

###### д. Татвар

###### Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Удирдлага НББ-ийг хэрхэн хетгэхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангaa хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

###### Хойшлогдсон албан татвар

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд “Тайлан тэнцлийн арга”-ыг ашиглан хойшлогдсон албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

д. Татвар(үргэлжлэл)

*Хойшлогдсон албан татвар(үргэлжлэл)*

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилнийг анх хүлээнзөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алиинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, тур зөрүү хэзээ арилахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасгдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасгдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алиинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасгдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүт хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дунг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчилэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дунг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үзэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

д. Татвар (үргэлжлэл)

*Хойшлогдсон албан татвар (үргэлжлэл)*

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суугтуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

*Нэмэгдсэн өртгийн албан татвар*

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддэг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед ут НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиromжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дун орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсгэг болгон толилуулна.

е. Бэлэн мөнгө болон банкин дахь данс

Бэлэн мөнгө болон банкин дахь дансанд банкинд байршуулсан мөнгө орно.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, дээр тодорхойлсноор бэлэн мөнгө болон банкин дахь харилцах, хадгаламж дахь бэлэн мөнгө болон богино хугацаатай хадгаламжийг банкны овердрафтын үлдэгдлийг багтаахгүйгээр оруулсан.

ё. Санхүүгийн хөрөнгө

(i) *Anх хүлээн зөвшөөрөх болон хэмжилт*

Санхүүгийн хөрөнгийт анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба авлага, дууставар хугацаа хүргэл эзэмшиж хөрөнгө оруулалт, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр ангилсан үүсмэл хэрэглүүр гэж ангилна. Санхүүгийн хөрөнгүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх гэж ангилаагүй санхүүгийн хөрөнгүүдийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлуудыг нэмж бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн бүх хэвийн худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр (Компани хөрөнгийг худалдан авах эсвэл зарах үүрэг хүлээсэн өдөр) хүлээн зөвшөөрнө.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

ë. Санхүүгийн хөрөнгө(үргэлжлэл)

(i) *Aих хүлээн зөвшөөрөх болон хэмжилт(үргэлжлэл)*

Компанийн санхүүгийн хөрөнгөнд бэлэн мөнгө болон банкин дахь данс ба бусад авлага ороно.

(ii) *Дараах үеийн хэмжилт*

*Зээл ба авлага*

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эзвэл тодорхойлж болох төлбөр бүхий үсмэл санхүүгийн хэрэглүүр биш санхүүгийн хөрөнгө юм. Аихны хэмжилтээс хойш санхүүгийн хөрөнгийг дараах үеүүдэд үзүүлэх цэнийн бууралтыг хассаны дараах үр ашигт хүүгийн арга (YAXA) ашиглан хорогдуулсан өргтөөр нь хэмжинэ. Хорогдуулсан нэргийг гүрашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалданавалтын урамшуулалт, хөнгөлөлт болон зардал, шимтгэлийг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалтын дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад орлого"-д багтана. Үнэцэнийн бууралтаасүүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад зардал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(iii) *Үл хүлээн зөвшөөрөлт*

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эзвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн ургсал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компанин тухайн хөрөнгөөс мөнгөн ургсал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дунгээр нь удаан хугацаагаар саатуулалтуйн таалд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл (a) Компани нь хөрөнгийн бараг бүх эрдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл (b) Компани нь тухайн хөрөнгөтэй холбоотой эрдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө.

Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууринар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дунгийн албагаар хэмжинэ.

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД– 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын төв чоо (үргэлжлэл)

###### ë. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

###### (iv) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг ноглох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлантгийн өдөр бүр үнэлж үзнэ.

Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн ургалдаа нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндэрлэл орсон, зээлийнхүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурах эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн ургалдаа хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

###### Хороходуулсан ортгоор нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дун ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн ургалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Орж ириэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн ургалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эредэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн ургалыг бууруулахад ашигласан хүрг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг санхүүгийн орлогын нэг хэсэг болгон орлого, зардлын дансанд бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийт борлуулсан эсвэл Компанид шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна.

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### ë. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

###### (iv) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах уйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг запруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Дансиас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдөл дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардал дансны кредитэд бүртгэнэ.

###### ж. Санхүүгийн өр төлбөр

###### (i) Ахны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийг аль зохицой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хайджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө.

Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дунгээр хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн өр төлбөрүүдэд дансны болон бусад өр төлбөр ба урьдчилж орсон орлого орно. Санхүүгийн өр төлбөрүүдийн хэмжилт дор дурдсан ангиллаас хамаарна:

###### Зээл, зээлтэг ба хойшлогдсон орлогын өр төлбөр

Анххэмжсэндэдараа, зээллэгүүд, хойшлогдсон орлогын өр төлбөр, хүүгийноглог, дансны болон бусад өгөгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өргтөөр нь хэмжинэ. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үсийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өргтгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох зээл олголтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэл, холбоотой зардлуудыг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд багтана.

###### (ii) Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрнөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзүүх ба бүртгэлийн дүнгийн зерүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### 3. Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

###### и. Бодит үнэ цэнээрх хэмжилт

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гээн. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуулад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Компани үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоо үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжинэ.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэд хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эсвэл хөрөнгийг хамгийн ур ашигтайгаар ашиглах зах зээлийн өөр нэг оролцогчид хөрөнгийг борлуулснаар эдийн засгийн өгөөжийг бий болгох зах зээлийн оролцогчийн чадварыг харгалзаж үнэ.

Компани тухайн нөхцөлд тохирох үнэлгээний техникуудийг ашиглах ба уг нөхцөл нь бодит үнэ цэнийг хэмжихэд шаардлагах хангалттай мэдээлтэй, холбогдох ажиглаж болохуйц орцуудыг дээд эзргээр, ажиглах боломжгүй орцуудыг хамгийн багаар ашиглана.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нелөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ,
- Түвшин 2 - шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нелөө үзүүлэх үнэлгээний техникид
- Түвшин 3 - ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нелөөтэй үнэлгээний техникид

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### и. Бодит үнэ цэнээрх хэмжилт (үргэлжлэл)

Компани санхүүгийн тайланд байнгын сууриар хүлээн зөвшөөрдөг хөрөнгө болон өр төлбөрүүдийн хувьд тайлант үе бүрийн эцэст ангиллыг дахин үнэлж (бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод суурилан) үссэнээр түвшний хоорондын шилжилт гарсан эсэхийг тодорхойлдог.

###### й. Урьдчилж төлсөн төлбөрүүд

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дунгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэгдсэн буюу хугацаа нь дуусахад орлогын тайланд тусгагддаг.

###### к. Үндсэн хөрөнгө


Үндсэн хөрөнгийг анхны өргтөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Хөрөнгийн ашиглалт дуусч эсвэл өртөг болон холбогдох хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт нь данснаас хасагдахад үүсэх олз болон гарз нь ашиг алдагдал кредитлэгдэнэ.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор шулуун шугамын аргаар, дараах ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

Ангилал	Жил
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга эд хогшил	10
Компьютер, түүнтэй адилтгах хөрөнгө	2
Барилга	25



2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

к. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтгэй холбогдон үссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн орлого, үр дүngийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашигийн хүлээгдэж буй хэрэглээний хувь загварт нийцж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцсэ бүрд хянаж үздэг.

л. Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнес нэгдлийн үед авсан биет бус хөрөнгийг авсан өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Дотооддоо хөгжүүлсэн биет бус хөрөнгийн хувьд хөгжүүлэлтийн зардлаас бусад зардал өргтийг нэмэгдүүлэхгүй. Үүний оронд холбогдох зарилуудыг зардал гарсан тайлант хугацаанд олз, гарзаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үзэлнэ. Компанийн эзэмшиж байгаа бүх биет бус хөрөнгүүд нь тодорхой ашиглалтын хугацаатай.

Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн тухай бурд үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хувь загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД- 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### л. Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Компанийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн програм хангамж бөгөөд шулуван шугамын аргыг ашиглан гурван (3) жил хорогдуулна.

###### м. Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотай гүйлгээний зардлыг татвар суутгасан дунгэр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өргтэгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өргтгөөс бусад өргтгийг оруулахгүй.

###### н. Холбоотой талуудын гүйлгээ


Холбоотой тал гэдэг нь Компанитай холбоотой хувь хүн эсвэл байгууллага байна.

(а) Хувь хүн эсвэл тухайн хүний гэр булийн ойрын гишүүн доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компанийн хяналт болон хамтын хяналт байдаг бол;
- (ii) Компанид томоохон нөлөөлөл байдаг бол;
- (iii) Компанийн гол удирдах ажилтан эсвэл Компанийн толгой компанийн гишүүн бол.

(б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компани болон аж ахуйн нэгж нь нэг группын гишүүд бол (өөрөөр хэлбэл толгой компани, охин компани ба зэргэлдээ охин компани бүр нь хоорондоо холбоотой юм);



## ГАН ХИЙЦ ХК

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД– 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

##### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

###### и. Холбоотой талуудын гүйлгээ


- (б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:
- (ii) иэг байгууллага нь нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, өөр байгууллага нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
  - (iii) хоёр компани хоёулаа нэг гуравдагч талын хамтын үйлдвэр бол;
  - (iv) нэгтгэл нь нөгөө талын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, нөгөө тал нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
  - (v) байгууллага нь Компанийн эсвэл Компанитай холбоотой талын ажилчдын тэтгэмжтэй холбоотой ажлаас гарсны дараах тэтгэмжийн хөтөлбөр бол. Хэрвээ Компани өөрөө тэр хөтөлбөр бол, ажил олгогчийн спонсор нь мөн Компанитай холбоотой тал болно;
  - (vi) (a)-д заасан хувь хүнд байгууллагын хяналт эсвэл хамтын хяналт байдаг бол;
  - (vii) (a)(i)-д заасан хувь хүнд байгууллагын томоохон нөлөө байх эсвэл тухайн хүн нь компанийн гол удирдах ажилтан бол (эсвэл толгой компанийн);
  - (viii) Компанид эсвэл Компанийн толгой компанийд гол удирдах ажилтанаар хангах үйлчилгээ үзүүлдэг байгууллага эсвэл группийн ямарваа гишүүн бол.

#### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ БА ТООЦООЛОЛ

Санхүүгийн тайлангүүдэг бэлтгэх ажил нь удирдлагастайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр, тайлант үеийн орлого, зардалд тайллагнасан дунд нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг. Эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дунд материалыг дүнтэй залруулаа хийхэд хүргэж болно. Тухайлбал, санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлагын авч үзсэн томоохон тооцооллын тухай мэдээллийг дор үзүүлэв:

*Бусад авлагын үнэ цэнийн бууралтыг тооцоолох*

Компани нь ирээдүйд авлагас учраас урчах боломжит алдагдлын хэмжээгээр үнэ цэний бууралтын сан байгуулдаг. Энэхүү сангийн дун нь удирдлагын түүхэн туршилага болон бусад эргэн төлөлтөд нөлөөлөхүйш хүчин зүйлүүдийн үнэлэмжээс шалтгаална. Тиймээс аль ч тайлант хугацаанд бүртгэсэн үнэ цэнийн бууралтын зардал нь тухайн жилийн үнэлэмж, тооцоолол болон төсөөллөөс хамааран өөрчлөгдж байдаг.



**ГАН ХИЙЦ ХК****САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД- 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31****4. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ /мянган төгрөгөөр/**

	<b>2021</b>	<b>2022</b>
Банкин дахь мөнгөн хөрөнгө	70,642	106,752
Касс дахь мөнгө	26	229,227
	<b>70,668</b>	<b>335,979</b>

Мөнгө түүнтэй адилгах хөрөнгө нь касс дахь мөнгө болон Голомт банк, Хаан банк, Хас банк дахь төгрөг, гадаад валютаас бүрдэж байна.

**5. ДАНСНЫ АВЛАГА**

	<b>2021</b>	<b>2022</b>
Дансны авлага	3,291,984	2,096,124
	<b>3,291,984</b>	<b>2,096,124</b>

**6. ТАТВАР, НДШ-Н АВЛАГА**

	<b>2021</b>	<b>2022</b>
ААНОАТ-ын авлага	-	-
НӨАТ-ын авлага	-	37,805
НДШ-ийн авлага	-	-
ХХОАТ-ын авлага	-	-
	<b>-</b>	<b>37,805</b>

**7. БУСАД БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА**

	<b>2021</b>	<b>2022</b>
Бусад талуудаас авах авлага	263,107	9,628
	<b>263,107</b>	<b>9,628</b>

**8. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**

	<b>2021</b>	<b>2022</b>
	-	5,144
	<b>-</b>	<b>5,144</b>

**9. БАРАА МАТЕРИАЛ**

	<b>2021</b>	<b>2022</b>
Түүхий эд материал	768,528	94,515
Дуусаагүй үйлдвэрлэл	310,121	3,130,544
Бэлэн бүтээгдэхүүн	112,034	998,797
Бусад	182	-
Хангамжийн материал	146,476	108,389
	<b>1,337,341</b>	<b>4,332,245</b>

## ГАН ХИЙЦ ХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД– 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

/мянган төгрөгөөр/

## 10. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

	2021	2022
Урьдчилж төлсөн зардал	1,206,431	234,754
	<b>1,206,431</b>	<b>234,754</b>

## 11. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	2021	Өсөлт	Бууралт	2022
<b>Анхны өртөг:</b>				
Барилга байгууламж	1,787,016	23,525	-	1,810,541
Машин, тоног төхөөрөмж	18,035	15,120	-	33,155
Тээврийн хэрэгсэл	136,664	224,917	-	361,582
Тавилга эд хогшил	655,475	-	-	655,475
Компьютер	3,065	1,833	-	4,898
Бусад хөрөнгө	-	-	-	-
	<b>2,600,255</b>	<b>265,395</b>	-	<b>2,865,650</b>
<b>Хүримтлагдсан элэглэл:</b>				
Барилга байгууламж	413,278	34,701	-	447,978
Машин, тоног төхөөрөмж	10,736	2,327	-	13,063
Тээврийн хэрэгсэл	74,027	16,428	-	90,455
Тавилга эд хогшил	356,106	32,925	-	389,031
Компьютер	557	1,405	-	1,962
Бусад хөрөнгө	-	-	-	-
	<b>854,704</b>	<b>87,787</b>	-	<b>942,490</b>
<b>Цэвэр дун:</b>				
Барилга байгууламж	1,373,738	-	-11,175	1,362,563
Тавилга эд хогшил	7,299	12,793	-	20,092
Машин, тоног төхөөрөмж	62,637	208,490	-	271,127
Тээврийн хэрэгсэл	299,369	-	-32,926	266,443
Компьютер, бусад хэрэгсэл	2,508	427	-	2,935
Бусад хөрөнгө	-	-	-	-
	<b>1,745,551</b>	<b>221,710</b>	<b>(44,101)</b>	<b>1,923,160</b>

## ГАН ХИЙЦ ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД—2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

/мянган төгрөгөөр/

## 12. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2021	Өсөлт	Бууралт	2022
<b>Анхны өртөг:</b>				
Зохиогчийн эрх	-	-	-	-
Компьютерийн программ хангамж	-	2,280	-	<b>2,280</b>
Патент	-	-	-	-
Тусгай зөвшөөрөл	-	-	-	-
Бусад бист бус хөрөнгө	-	-	-	-
<b>Хүримтлагдсан элэглэл:</b>				
Зохиогчийн эрх	-	-	-	-
Компьютерийн программ хангамж	-	38	-	<b>38</b>
Патент	-	-	-	-
Тусгай зөвшөөрөл	-	-	-	-
Бусад бист бус хөрөнгө	-	-	-	-
<b>Цэвэр дүн:</b>				
Зохиогчийн эрх	-	-	-	-
Компьютерийн программ хангамж	-	2,242	-	<b>2,242</b>
Патент	-	-	-	-
Тусгай зөвшөөрөл	-	-	-	-
Бусад бист бус хөрөнгө	-	-	-	-
	<b>2,242</b>		<b>2,242</b>	

## 13. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2021	2022
Урт хугацаат хөрөнгө оруулалт	323,133	323,133
	<b>323,133</b>	<b>323,133</b>

## 14. ДАНСНЫ ӨГЛӨГ

	2021	2022
Дансны өглөг	4,361,920	2,437,814
	<b>4,361,920</b>	<b>2,437,814</b>

## 15. ТАТВАРЫН ӨГЛӨГ

	2021	2022
ААНОАТ-ын өглөг	12,473	87,467
НӨАТ-ын өглөг	347,984	139,476
ХХОАТ-ын өглөг	27,745	13,152
Бусад татварын өр	66,000	1,086
ҮЭ	11,057	11,057
	<b>465,259</b>	<b>252,238</b>

ГАН ХИЙЦ ХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД—2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15.1 ТАТВАРЫН ЗАРДАЛ

/мянган төгрөгөөр/

Татварын зардал

	2021	2022
Татварын зардал	14,968	72,126
	<b>14,098</b>	<b>72,126</b>

16. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

Төлөгдөх хугацаандаа байгаа

	2021	2022
Төлөгдөх хугацаандаа байгаа	500,000	1,375,000
	<b>500,000</b>	<b>1,375,000</b>

17. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Өмч - хувийн

	2021	2022
Өмч - хувийн	24,246	24,246
	<b>24,246</b>	<b>24,246</b>

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн № 9010001016 тоот гэрчилгээ авсан болно.

18. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

	2021	2022
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	798,701	798,701
	<b>798,701</b>	<b>798,701</b>

19. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Борлуулалтын орлого

	2021	2022
Борлуулалтын орлого	3,461,006	7,340,486
	<b>3,461,006</b>	<b>7,340,486</b>

20. БОРЛУУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨРТӨГ


Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

	2021	2022
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,587,673	6,140,742
	<b>2,587,673</b>	<b>6,140,742</b>

21. БУСАД ОРЛОГО

Түрэсийн орлого  
Бусад орлого

	2021	2022
Түрэсийн орлого	-	271,291
Бусад орлого	-	127,307
	<b>-</b>	<b>398,598</b>



**ГАН ХИЙЦ ХК****САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД – 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

/мянган төгрөгөөр/

**22. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ**

	<b>2021</b>	<b>2022</b>
Ажилчдын цалингийн зардал	370,978	328,483
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-н зардал	27,699	50,576
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	49,830	54,704
Томилолтын зардал		3,615
Бичиг хэргийн зардал	4,504	5,263
Шуудан холбооны зардал	9,897	7,280
Мэргэжлийн үйлчилгээний зардал	34,170	17,686
Сургалтын зардал	4,598	10,863
Сонин сэтгүүл захиалгын зардал		
Даатгалын зардал	5,397	1,047
Ашиглалтын зардал	4,588	38,055
Засварын зардал	26,263	51,721
Эзлэдэл, хорогдлын зардал	66,043	51,470
Түрээсийн зардал		30,175
Харуул хамгаалалтын зардал	9,588	21,657
Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	13,769	3,179
Тээврийн зардал		1,525
Шатахаууны зардал	12,760	24,643
Хүлээн авалтын зардал		28,421
Зар сурталчилгааны зардал	4,140	3,737
Шимтгэл	2,120	7,062
Бусад зардал	70,155	19,016
	<b>716,499</b>	<b>760,178</b>

**23. БУСАД ЗАРДАЛ**

	<b>2021</b>	<b>2022</b>
Алданги, торгуулийн зардал	93,121	24,028
	<b>93,121</b>	<b>24,028</b>

